



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 744

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 6 нэрийн нийт 54,338,600.00 /тавин дөрвөн сая гурван зуун гучин найман мянга зургаан зуун/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
 744 дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн
 хөрөнгөд шинээр бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Хувилагч /Xerox Versa Link B7025	12/24/2019	2	7,615,000.00	15,230,000.00
2	Компьютер /Dell Optiplex 7070MT i7-9700 8GB 1TB/	12/25/2019	6	2,399,900.00	14,399,400.00
3	Монитор /Dell E1916H 18.5 monitor/	12/25/2019	7	249,900.00	1,749,300.00
4	Компьютер /Dell Optiplex 7070MT i7-9700 8GB 1TB/	12/24/2019	1	2,399,900.00	2,399,900.00
5	Зөөврийн таблет (Microsoft Surface Pro 7 12.3,i5,8G,128G,Notebook tablet)	12/26/2019	2	3,380,000.00	6,760,000.00
6	Архивын тавиур	12/31/2016	12	1,150,000.00	13,800,000.00
	Нийт дүн		30		54,338,600.00 /тавин дөрвөн сая гурван зуун гучин найман мянга зургаан зуун/